



БАГАНУУР ЗҮҮН
ӨМНЭЛ СҮСЭЙН
ЦАХИЛГААН ГҮЗЭХ
СҮСКЭС ТӨХЖИЙН
ГОВЬСУМБЭР САЛБАРЫН
ДАРГА

Б. БАТТУУЛ

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2023 оны 01 дүгээр сарын 17-ний өдөр

№01/23

Говьсүмбэр аймаг

1. Техникийн нөхцөл хүссэн
хуулийн этгээд болон

Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн захирал Б.Магсаржав

байгууллага

2. Хэрэглэгчийн хаяг:

Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэр

3. Хэрэглэгчийн байршил,
зэрэглэл:

Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэр
III зэрэглэл

4. Ажил үйлчилгээний
зориулалт

36 айлын орон сууц

5. Техникийн нөхцөл олгох
үндэслэл:

36 айлын 3 давхар орон сууцны зориулалтаар

6. Суурилагдсан чадал:

100 kWt

7. Холбогдох цэг:

7.1 Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, 2-р багт байрлах, 36 айлын орон
сууцны 380 В-ын цахилгаан хангамжийг 6/0.4 кВ ТП-99 дэд өртөөнд
ШО-70 маягийн щит сууринуулж 95 мм²-аас багагүй хөндлөн
огтлолтой хос кабель шугамаар тэжээнэ.

8. Тоолуур хэмжих
хэрэгсэл:

8.1 Шинээр гаргаж, салбарлаж буй шугамын эхэнд ачаалалд тохирсон
автомат ба стандартчлал хэмжил зүйн төвөөс загварын
туршилтанд орж ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан гурван
фазын 3G, 4G сүлжээнд ашиглах боломжтой RS485 порт бүхий
оролттой бүрэн ухаалаг тоолуур монтажилж, мэдээлэл цуглуулах
дата концентратор суулгаж, щитний хайрцаг сууринуулж тавина.

8.2 Кабелийг газраар 0.7 м-ээс багагүй ухсан шуудуугаар явуулах ба
үзүүрүүдэд төгсгөөвч, орчин үеийн шинэ технологийт муфтын хийж
холбох ба галын аюулгүй байдлыг хангаж, угсарна.

8.3 Кабель шугамын төгсгөлд гаргалгааны ачаалалд тохирсон
автомат, рубильник, цэнэг шавхагч бүхий щитний хайрцаг
сууринуулна.

8.4 Айл өрхийн ачаалалд тохирсон автомат ба стандартчлал хэмжил
зүйн төвөөс загварын туршилтанд орж ашиглахыг зөвшөөрч
баталгаажуулсан нэг фазын 3G, 4G сүлжээнд ашиглах боломжтой
RS485 порт бүхий оролттой бүрэн ухаалаг тоолуур сууринуулна.

9. Тусгай заалтууд:

9.1 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшилийн газар нутаг,
инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс
зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурvas, газрын
зөвшөөрлийн талаар холбогдох албан газраас нь зөвшөөрөл авна.

9.2 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн
түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын
нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ
найдвартай тооног төхөөрөмж сууринуулна.



9.3 Цахилгааны оруулга, гаргалгааны кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.4 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт хэмжилтийг "БЗӨБЦТС" ТӨХК-иар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

9.5 Төхникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу цахилгаан түгээх сүлжээнд холбогдоно.

9.6 Шинээр сууринлагдах 380 В щитний хайрцаагт "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.41-н дагуу газардуулга хийх, газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос ихгүй байхаар хийж гүйцэтгэнэ.

9.7 Шинээр баригдах 36 айлын орон сууц нь ерөнхий щитний өрөөтэй байна.

9.8 Ерөнхий щитний өрөөнөөс орц бүрт ачаалалд тохирсон кабель татагдах ба давхар бүрт тоолуур автомат бүхий зориулалтын иж бүрэн самбар сууринлуулна.

10. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Цахилгаан тоноглол болон кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК-ийн Говьсүмбэр салбарын Шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах үйл ажиллагааны хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажилана.

10.2 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилана.

10.3 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.10 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.4 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.5 Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

10.6 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 32.3.2, 32.3.3 дахь заалтуудын дагуу цахилгаан эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөлийг зөрчсөн, гэрээгээр заасан цахилгаан чадлыг хэтрүүлсэн тохиолдолд цахилгаан эрчим хүчээр түдгэлзүүлнэ.

ХЯНАСАН:

ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЕНЕЖЕР, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АШИГЛАЛТ ЗАСВАРЫН ИНЖЕНЕР



Е.БОЛДБААТАР

Б.ЭНХЖАРГАЛ

З.БАТЦООЖ



Scanned with
MOBILE SCANNER